



*Алтангэрэл*

БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/105

Улаанбаатар хот

Ёс зүйн хороо байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Төрийн албаны тухай хуулийн 7.1.7, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан дүрмийн 2.1, 2.2, "Журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын 2.1, 2.2, 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Ёс зүйн хороог яамны албан хаагчдаас өгсөн саналын дагуу дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Хорооны дарга	Т.Алтангэрэл	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Гишүүд	А.Сайнбаяр	Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Н.Молор	Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн
	Л.Эрдэнэбулган	Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Усны нөөцийн хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Т.Болдбаатар	Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын мэргэжилтэн

2.Төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, иргэдээс ирүүлсэн төрийн захиргааны албан хаагчтай холбоотой гомдол мэдээллийн талаар тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо, баримт бичгийг шаардан авах, ёс зүйн зөрчлийг шалган тогтоож, дүгнэлт гаргахтай холбоотой төлөвлөгөө боловсруулж, ажиллахыг Ёс зүйн хорооны дарга /Т.Алтангэрэл/-д үүрэг болгосугай.

3.Төрийн үйлчилгээний албан хаагчийн хувьд нэгэн адил дагаж мөрдсүгэй.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Ёс зүйн хороо байгуулах тухай" Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А-139 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА  Ц.ЦЭНГЭЛ

